

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
П.БАТБААТАР ТАНАА

2021.02.25 № 07/497
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр нийт 50 ажил, арга хэмжээ төлөвлөж ажилласнаас 99.0 хувийн хэрэгжилттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,241,976,228.24	4,612,168,855.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,393,680.00	935,618,420.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,393,680.00	935,618,420.50
3121	Төгрөг	1,393,680.00	935,618,420.50
31211	Төрийн сангийн харилцах	1,393,680.00	1,617,680.00
31214	Бусад төсөл нөөцийн харилцах	-	934,000,740.50
33	АВЛАГА	38,855,365.00	17,682,424.00
335	Бусад авлага	38,855,365.00	17,682,424.00
3351	Байгууллагаас авах авлага	21,172,941.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	17,682,424.00	17,682,424.00
34	УРЬДЧИЛГАА	47,230,920.00	170,383,547.00
34600	Урьдчилж гарсан зардал	47,230,920.00	170,383,547.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,154,496,263.24	3,488,484,463.91
351	Түүхий эд материал	444,863,790.66	1,024,823,314.48
35110	Тусгай зориулалттай материал	440,973,863.06	914,418,073.61
35130	Эм боох материал	3,889,927.60	110,405,240.87
35300	Бэлэн бүтээгдэхүүн	675,823,566.90	793,535,896.25
354	Хангамжийн материал	1,033,808,905.68	1,670,125,253.18
35410	Бичиг хэргийн материал	56,176,970.50	96,356,897.00
35420	Аж ахуйн материал	717,555,546.96	832,589,381.96
35430	Сэлбэг хэрэгсэл	23,051,000.00	62,151,460.00
35440	Түлш, шатах тослох материал	5,085,639.25	72,489,871.25
35450	Барилгын засварын материал	154,459,677.00	331,511,072.00
35460	Хүнсний материал	26,060,739.97	190,134,192.97
35470	Бусад хангамжийн материал	51,419,332.00	84,892,378.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	67,145,110,473.63	89,833,276,748.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	67,145,110,473.63	89,833,276,748.02
392	Биет хөрөнгө	52,896,474,019.33	75,578,890,180.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	48,922,619,070.50	69,821,650,906.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,538,395,141.12	-3,591,054,257.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	888,450,532.00	2,168,181,202.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-827,683,751.73	-809,270,929.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,649,918,546.33	6,625,731,363.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,695,947,882.02	-2,176,405,116.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,311,712,177.60	3,070,413,033.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,172,463,562.93	-1,476,303,035.54
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	355,709,130.00	355,709,130.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-22,736,286.00	-23,411,286.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,130,991,015.35	1,130,991,015.35
39215	Хуримтлагдсан элэгдэл	-167,438,559.50	-223,348,576.70
39216	Дуусаагүй барилга, байгууламж	2,400,000,000.00	-
39217	Ном	661,738,730.85	706,006,730.85
393	Биет бус хөрөнгө	14,248,636,454.30	14,254,386,567.91
39301	Програм хангамж	63,818,605.50	52,548,605.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	-55,464,931.20	-38,444,817.59
39305	Газар эзэмших эрх	14,240,282,780.00	14,240,282,780.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	69,387,086,701.87	94,445,445,603.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,393,680.00	935,618,420.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,393,680.00	935,618,420.50
413	Өглөг	-	934,000,740.50
4136	Бусад өглөг	-	934,000,740.50

41361	Байгууллагад төлөх өглөг	-	934,000,740.50
414	Урьдчилж орсон орлого	1,393,680.00	1,617,680.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,393,680.00	1,617,680.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	69,385,693,021.87	93,509,827,182.93
51	Засгийн газрын хувь оролцоо	69,385,693,021.87	93,509,827,182.93
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,588,860,843.91	5,588,860,843.91
51200	Хуримтлагдсан үр дүн	42,180,309,522.32	66,304,443,683.38
51210	Өмнөх үеийн үр дүн	42,180,309,522.32	42,180,309,522.32
51220	Тайлант үеийн үр дүн	-	24,124,134,161.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,616,522,655.64	21,616,522,655.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	69,387,086,701.87	94,445,445,603.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
төгрөгөөр

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	16,704,222,160.33	41,501,231,517.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,043,610,016.33	9,366,180,968.51
120	Нийтлэг татварын бус орлого	851,782,161.39	9,366,180,968.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	789,442,805.80	5,019,669,427.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	773,894,850.00	860,886,435.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,547,955.80	7,852,709.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	4,150,930,283.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	62,339,355.59	4,230,159,842.96
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	116,351,698.55
122	Тусламжийн орлого	191,827,854.94	-
122001	Хандив тусламж /дотоод/	191,827,854.94	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,660,612,144.00	32,135,050,548.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,216,123,900.00	30,915,221,740.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,816,123,900.00	14,817,150,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	2,400,000,000.00	16,098,071,040.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,444,488,244.00	1,219,828,808.85
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	154,523,644.00	26,535,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	986,768,000.00	967,417,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	303,196,600.00	225,875,908.85
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,634,711,263.18	17,377,097,356.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,634,711,263.18	17,377,097,356.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,609,938,702.54	15,523,067,104.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,912,998,064.00	9,250,741,394.00
210101	Үндсэн цалин	4,406,678,300.00	4,974,929,794.00
210102	Нэмэгдэл	3,276,384,564.00	4,045,876,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,935,200.00	229,935,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,929,959.00	785,409,786.42
210201	Тэтгэврийн даатгал	40,810,000.00	711,240,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,670,900.00	17,823,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,536,900.00	1,128,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,134,200.00	282,000.00

Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	167,777,959.00	54,935,786.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	597,180,782.76	510,057,991.24
210301	Гэрэл, цахилгаан	258,301,265.39	238,452,354.37
210302	Түлш, халаалт	251,229,275.96	216,236,963.00
210303	Цэвэр, бохир ус	87,650,241.41	55,368,673.87
2104	Хангамж, бараа материалын зардал	448,248,632.84	264,071,700.40
210401	Бичиг хэрэг	145,677,366.40	103,359,090.50
210402	Тээвэр, шатахуун	78,725,180.00	69,445,476.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,731,188.04	28,978,518.90
210404	Ном, хэвлэл	6,105,405.00	17,515,014.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,855,168.40	44,773,601.00
210408	Бараа материал акталсны зардал	141,154,325.00	-
2105	Нормативт зардал	1,679,642,647.17	2,013,687,776.23
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,090,048.70	179,766,062.73
210502	Хоол, хүнс	1,006,054,165.86	772,771,001.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	643,498,432.61	1,061,150,711.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	297,448,750.00	224,384,758.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	2,025,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,726,578.00	23,509,046.00
210604	Урсгал засвар	289,422,172.00	198,850,712.00
2107	Томилолт, зочны зардал	46,709,200.00	10,160,800.00
210701	Гадаад томилолтын зардал	-	8,207,800.00
210702	Дотоод томилолтын зардал	29,029,800.00	1,233,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	17,679,400.00	720,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,154,140,756.36	106,389,178.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,118,074,781.36	59,587,238.00
210803	Даатгалын үйлчилгээ	14,664,800.00	15,765,844.56
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,852,275.00	3,810,846.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,012,000.00	935,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,536,900.00	26,290,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,253,639,910.41	2,358,163,719.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,375,300.00	4,170,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	403,288,612.00	390,652,851.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,808,975,998.41	1,963,340,668.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,024,772,560.64	1,854,030,251.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	958,049,414.00	1,728,388,235.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,825,578.00	9,105,822.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,212,800.00	35,642,053.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	624,473,536.00	630,439,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	304,537,500.00	1,053,200,680.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,723,146.64	125,642,016.88
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг (нэмэлт)	-	3,000.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,723,146.64	117,099,812.88
213304	Хөрөнгийн	-	8,539,204.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,069,510,897.15	24,124,134,161.06
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	380,942,315.41	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	332,613,091.41	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	48,329,224.00	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	688,568,581.74	24,124,134,161.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	16,451,448,629.80	33,938,014,433.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	790,836,485.80	1,802,963,884.50
120	Нийтлэг татварын бус орлого	790,836,485.80	1,802,963,884.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	790,836,485.80	868,963,144.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	775,288,530.00	861,110,435.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,547,955.80	7,852,709.00
120009	Бусад орлого	-	934,000,740.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,660,612,144.00	32,135,050,548.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,216,123,900.00	30,915,221,740.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,816,123,900.00	14,817,150,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	2,400,000,000.00	16,098,071,040.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,444,488,244.00	1,219,828,808.85
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	154,523,644.00	26,535,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	986,768,000.00	967,417,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	303,196,600.00	225,875,908.85
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,656,835,890.80	16,263,844,265.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,656,835,890.80	16,263,844,265.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,671,186,806.16	14,262,235,208.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,912,998,064.00	9,239,818,453.00
210101	Үндсэн цалин	4,406,678,300.00	4,964,006,853.00
210102	Нэмэгдэл	3,276,384,564.00	4,045,876,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,935,200.00	229,935,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,852,900.00	785,409,786.42
210201	Тэтгэврийн даатгал	40,810,000.00	711,240,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,670,900.00	17,823,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,536,900.00	1,128,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,134,200.00	282,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	178,700,900.00	54,935,786.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	597,180,782.76	510,057,991.24
210301	Гэрэл, цахилгаан	258,301,265.39	238,452,354.37
210302	Түлш, халаалт	251,229,275.96	216,236,963.00
210303	Цэвэр, бохир ус	87,650,241.41	55,368,673.87
2104	Хангамж, бараа материалын зардал	208,550,093.04	299,124,161.90
210401	Бичиг хэрэг	37,623,800.00	26,570,600.00
210402	Тээвэр, шатахуун	79,310,000.00	133,625,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,731,188.04	28,978,518.90
210404	Ном, хэвлэл	8,349,805.00	17,944,812.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,535,300.00	92,004,331.00
2105	Нормативт зардал	1,681,711,956.00	2,358,136,485.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,251,600.00	274,402,631.00
210502	Хоол, хүнс	859,041,356.00	936,844,454.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,419,000.00	1,146,889,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	280,430,834.00	384,287,663.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,710,000.00	15,660,643.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	33,802,200.00	46,516,700.00
210604	Урсгал засвар	244,918,634.00	322,110,320.00
2107	Томилолт, зочны зардал	46,502,800.00	21,459,400.00

210701	Гадаад албан томилолт	-	8,207,800.00
210702	Дотоод албан томилолт	29,029,800.00	1,233,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	17,473,000.00	12,018,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,185,766,276.36	126,697,060.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,139,038,931.36	60,157,520.00
210803	Даатгалын үйлчилгээ	14,664,800.00	15,765,844.56
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,852,275.00	3,810,846.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,012,000.00	935,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,198,270.00	46,027,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	527,193,100.00	537,244,207.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,540,300.00	11,819,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	480,652,800.00	525,425,207.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	985,649,084.64	2,001,609,056.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	918,925,938.00	1,875,967,040.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,212,800.00	35,642,053.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	604,175,638.00	753,592,307.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	304,537,500.00	1,086,732,680.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,723,146.64	125,642,016.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,723,146.64	117,099,812.88
213304	Хөрөнгийн	-	8,539,204.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,794,612,739.00	17,674,170,167.50
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,793,219,059.00	16,739,945,427.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,793,219,059.00	16,739,945,427.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,793,219,059.00	16,739,945,427.00
220001	Барилга байгууламж	2,400,000,000.00	16,089,531,836.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	393,219,059.00	650,413,591.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-2,793,219,059.00	-16,739,945,427.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,393,680.00	934,224,740.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,393,680.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,393,680.00	935,618,420.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	26,716,081,740.62	36,392,181,855.60	68,697,124,440.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,099,559,084.98	5,099,559,084.98
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	26,716,081,740.62	41,491,740,940.58	73,796,683,525.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-5,099,559,084.98	-	-5,099,559,084.98
Тайлант үеийн үр дүн	-	-	688,568,581.74	688,568,581.74
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	42,180,309,522.32	69,385,693,021.87
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	42,180,309,522.32	69,385,693,021.87
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	42,180,309,522.32	69,385,693,021.87
Тайлант үеийн үр дүн	-	-	24,124,134,161.06	24,124,134,161.06
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	21,616,522,655.64	66,304,443,683.38	93,509,827,182.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,769,519,800.00	31,658,321,867.12	111,197,932.88	99.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,669,519,800.00	15,568,790,031.12	100,729,768.88	99.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,734,239,000.00	14,650,002,991.12	84,236,008.88	99.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,242,372,900.00	9,239,818,453.00	2,554,447.00	99.97
210101	Үндсэн цалин	4,964,023,700.00	4,964,006,853.00	16,847.00	100.0
210102	Нэмэгдэл	4,048,414,000.00	4,045,876,400.00	2,537,600.00	99.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,935,200.00	229,935,200.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	811,286,400.00	785,409,786.42	25,876,613.58	96.81
210201	Тэтгэврийн даатгал	711,240,100.00	711,240,100.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,639,000.00	17,823,300.00	2,815,700.00	86.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,515,100.00	1,128,600.00	3,386,500.00	25.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,128,600.00	282,000.00	846,600.00	24.00
210205	Эрүүл мэндийн даатгал	73,763,600.00	54,935,786.42	18,827,813.58	74.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	528,229,100.00	510,057,991.24	18,171,108.76	96.56
210301	Гэрэл, цахилгаан	256,623,400.00	238,452,354.37	18,171,045.63	92.92
210302	Түлш, халаалт	216,237,000.00	216,236,963.00	37.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	55,368,700.00	55,368,673.87	26.13	100.00

Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	334,886,100.00	328,381,661.90	6,504,438.10	98.06
210401	Бичиг хэрэг	26,570,600.00	26,570,600.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	133,625,900.00	133,625,900.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,605,900.00	28,978,518.90	627,381.10	97.88
210404	Ном, хэвлэл	53,076,400.00	47,202,312.00	5,874,088.00	88.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,007,300.00	92,004,331.00	2,969.00	100.00
2105	Нормативт зардал	2,323,245,300.00	2,311,482,513.00	11,762,787.00	99.49
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	278,388,900.00	278,121,658.00	267,242.00	99.90
210502	Хоол, хүнс	897,967,000.00	886,471,455.00	11,495,545.00	98.72
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,146,889,400.00	1,146,889,400.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	753,696,200.00	753,319,518.00	376,682.00	99.95
210601	Багаж, техник, хэрэгсэл	296,800,200.00	296,423,518.00	376,682.00	99.87
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	104,116,700.00	104,116,700.00	-	100.00
210604	Урсгал засвар	352,779,300.00	352,779,300.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	23,898,300.00	21,459,400.00	2,438,900.00	89.79
210701	Гадаад албан томилолт	8,207,800.00	8,207,800.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	1,233,000.00	1,233,000.00	-	100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	14,457,500.00	12,018,600.00	2,438,900.00	83.13
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,355,500.00	101,947,460.56	10,408,039.44	90.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,804,600.00	11,804,520.00	80.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	16,714,800.00	15,765,844.56	948,955.44	94.32
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,904,700.00	3,810,846.00	93,854.00	97.60
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,177,000.00	935,000.00	242,000.00	79.44
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	78,754,400.00	69,631,250.00	9,123,150.00	88.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	604,269,200.00	598,126,207.00	6,142,993.00	98.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,538,100.00	11,819,000.00	5,719,100.00	67.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	586,731,100.00	586,307,207.00	423,893.00	99.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	935,280,800.00	918,787,040.00	16,493,760.00	98.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	935,280,800.00	918,787,040.00	16,493,760.00	98.24
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,742,200.00	35,642,053.00	100,147.00	99.72
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	781,888,600.00	753,592,307.00	28,296,293.00	96.38
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	117,650,000.00	129,552,680.00	-11,902,680.00	110.12
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,100,000,000.00	16,089,531,836.00	10,468,164.00	99.93
220001	Барилга байгууламж	16,100,000,000.00	16,089,531,836.00	10,468,164.00	99.93
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,769,519,800.00	31,658,321,867.12	111,197,932.00	99.65

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,922,869,800.00	30,789,582,723.12	133,287,076.88	99.57
310001	Улсын төсвөөс санхүүжих	30,922,869,800.00	30,789,582,723.12	133,287,076.88	99.57
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	846,650,000.00	868,739,144.00	-22,089,144.00	102.61
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	840,750,000.00	861,110,435.00	-20,360,435.00	102.42
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,900,000.00	7,628,709.00	-1,728,709.00	129.30
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	497	497		100.0
620001	Удирдах ажилтан	5	5		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	422	422		100.0
620003	Үйлчлэх ажилтан	70	70		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,219,828,808.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,219,828,808.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		262,645,808.85
2105	Нормативт зардал		56,553,972.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		6,180,973.00
210502	Хоол, хүнс		50,372,999.85
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		149,556,836.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		149,556,836.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		56,535,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		56,535,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		957,183,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		957,180,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		957,180,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,000.0
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		3,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,219,828,808.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,219,828,808.85
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		26,535,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		967,417,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		225,875,908.85

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал П.Батбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл болон даатгалын зардлын нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Д.Мөнхжин нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орчин үеийн их сургуулийн жишиг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр, багшийн заах арга зүйг сайжруулах замаар сургалтын чанар, үр дүнг дээшлүүлж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан цогц чадамж бүхий мэргэжилтэн бэлтгэнэ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо, чанар, практик үр өгөөжийг нэмэгдүүлж, салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн дэд бүтцийг бий болгож, улс орны хөгжил дэвшилд хувь нэмэр оруулагч судалгааны их сургууль болно.
- Олон улсын жишиг, Их сургуулийн эрхэм зорилгод нийцсэн сургалт, судалгаа, туршилт-боловсруулалтын материаллаг бааз, багш, судлаач, суралцагчийн ажиллах, суралцах, бие даан хөгжих боломжийг хангасан орчин нөхцлийг бүрдүүлнэ.
- Их сургуулийн мэдлэг оюуны чадавх, соёл, уламжлалыг тээгч багш, судлаач, ажилтан, суралцагчийг бүх талаар хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, мэргэшсэн, хариуцлага, ёс зүйтэй, тэргүүний хамт олон, суралцагч байгууллага болно.
- Тогтвортой хөгжлийг дэмжсэн оновчтой бодлого хэрэгжүүлж, үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлж, их сургуулийн гадаад, дотоод нэр хүнд, байр суурийг бэхжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандивын судалгаагаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Цагдаагийн мэргэжлийн коллежоос 3,500.0 мянган төгрөгийн амны хаалт, ХЗДХЯ-наас 32,909.5 мянган төгрөгийн амны хаалт, халдваргүйжүүлэх уусмал зэрэг нийт 36,409.5 мянган төгрөгийн хандив авсан байна.

Мөн цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ХЗДХС-ын 2020 оны А/219 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан 3,689,541.0 мянган төгрөгөөс гүйцэтгэлээр 3,159,543.9 мянган төгрөгийн худалдан авалт хийж, тухайлбал, хүнсний барааны худалдан авалтаас 452,886.1 мянган төгрөг дутуу зарцуулсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дотоод хэргийн их сургууль санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт 4, төлөвлөгөөт бус 5 дотоод аудит, мөн санхүүгийн хяналт шалгалт хийж үйл ажиллагаа сайжруулах зөвлөмжүүдийг өгч биелэлтийг үнэлж ажилласан байна. Үүнээс, төв номын сангийн үйл ажиллагааг шалгаж номын сангийн журмын холбогдох заалтыг мөрдөж ажиллах 6 зөвлөмжийн биелэлт 80 хувьтай, бусад зөвлөмжүүдийг цаг тухайд нь хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд хийсэн дотоод аудитаар ашиг сонирхлын мэдүүлгийг тухай бүр оруулж хэвших зөвлөмж өгч хэрэгжилтийг хянасан байна.

Дотоод хэргийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны батлагдсан төсвийн урсгал зардал 15,481,519.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 309,630.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад тайлант оны төсвийн гүйцэтгэлээр урсгал зардлын дүн 15,559,692.9 мянган төгрөг болж өөрчлөгдсөн боловч тогтоосон материаллаг байдлыг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,058,358.9 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,241,976.2	4,612,168.8	2,370,192.6
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	1,393.7	935,618.4	934,224.7
АВЛАГА	38,855.4	17,682.4	(21,173.0)
УРЬДЧИЛГАА	47,230.9	170,383.5	123,152.6
БАРАА МАТЕРИАЛ	2,154,496.3	3,488,484.5	1,333,988.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	67,145,110.5	89,833,276.7	22,688,166.2
Биет хөрөнгө	52,896,474.0	75,578,890.2	22,682,416.2
Биет бус хөрөнгө	14,248,636.5	14,254,386.6	5,750.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	69,387,086.7	94,445,445.6	25,058,358.9
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,393.7	935,618.4	934,224.7
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,393.7	935,618.4	934,224.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	69,385,693.0	93,509,827.2	24,124,134.2

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,588,860.8	5,588,860.8	-
Хуримтлагдсан үр дүн	42,180,309.5	66,304,443.7	24,124,134.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,616,522.7	21,616,522.7	-
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	69,387,086.7	94,445,445.6	25,058,358.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 934,224.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барьцааны хөрөнгөөс шалтгаалжээ. Энэ нь Билгүүн монгол констракшн ХХК-д шилжүүлэх нийт санхүүжилтийн 5 хувь байна. Мөн энэ нь санхүүгийн тайланд өр төлбөрөөр туссан байна.

Авлага дансны үлдэгдэл 17,682.4 мянган төгрөг нь 2003 онд үүссэн хувь хүнээс авах авлага бөгөөд 2019 онд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газраас төлбөр төлөгч нь эрхэлсэн тодорхой ажилгүй, хөрөнгө орлогогүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашрах нөхцөл байдал үүссэн талаар мэдэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,333,988.2 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал болон хангамжийн материалын өсөлтөөс шалтгаалжээ.

Харин бараа материалын дансны үлдэгдлийн 26.2 хувь буюу 914,418.0 мянган төгрөг нь тусгай зориулалтын материал байна. Тайлант онд БНСУ-ын Эксим банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд тусгай зориулалтын хэрэгсэл 354,574.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,688,166.2 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж, тайлант онд ашиглалтанд орсон шинэ номын сан, спорт цогцолборын барилга болон суурилуулсан тоног төхөөрөмж нэмэгдсэнтэй холбоотой байна. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 16,098,071.0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 650,413.6 мянган төгрөгөөр, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 4,643,906.9 мянган төгрөг нь гадаад эх үүсвэрээс, ХЗДХЯ-ны хөрөнгө оруулалтаар 2,401,639.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2020 оны 314 дүгээр тогтоолоор нийт 105,232.8 мянган төгрөгийн 17 нэр төрлийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг акталснаар үндсэн хөрөнгийн данс буурсан байна.

Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 24,797,009.4 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилгын санхүүжилт болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнгээр нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,742,386.1 мянган төгрөгөөр өссөн нь цалин, хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолын 1 дугаар хавсралтын 3-д “Төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг бодохдоо алба хаагчийн ажилласан жилийн нэмэгдлийг нэмж тооцно”, 2015 оны 240 дүгээр тогтоолын 2-д “Хууль сахиулахын их сургуулийн албан хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны, албан ажлын онцгой нөхцөлийн, цол, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тус тус цагдаагийн албан хаагчид олгож байгаа нэмэгдлийн хувь, хэмжээтэй адилтган тооцон олгож, ...” гэж заасны дагуу цалингийн зардал нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант оны үр дүн нэмэгдсэнээс бусад өөрчлөлт ороогүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийг 32,005,423.7 мянган төгрөгөөр, үүнээс урсгал зардлын төсвийг 15,907,352.7 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 16,098,071.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 243,552.0 мянган төгрөгөөр бууруулж баталснаас бараа, үйлчилгээний зардлыг 328,720.7 мянган төгрөг бууруулж, урсгал шилжүүлгийг 85,168.7 мянган төгрөгөөр нэмж тодотгол хийж баталсан байна.

2020 онд Дотоод хэргийн их сургуулийн Спорт цогцолбор, номын сангийн барилга ашиглалтад орсонтой холбогдуулан үйлчлэгч, бассейны сургагч багш, аврагч, эмч, номын санч, тогооч, инженер техникийн ажилтан, лаборант нийт 61 орон тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлын 736.6 сая төгрөгийн саналыг 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөлд тусган Сангийн яаманд хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70713 буюу 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 31,769,519.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 30,922,869.8 мянган төгрөгийг улсын төсвөөс 846,650.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 30,915,221.7 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 868,963.1 мянган төгрөг, нийт 31,784,184.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 15,568,790.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 16,089,531.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 125,863.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.7 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 25,876.6 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 18,171.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар Дэлхийн байгаль хамгаалах сангаас 22,535.0 мянга, ХЗДХЯ-наас 967,417.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 76,316.0 мянга, давсан орлого 149,559.8 мянга, бусад орлого 4,000.0 мянга, нийт 1,219,828.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулагдаагүй үлдэгдэл 3.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Дэлхийн байгаль хамгаалах сангаас “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах боломжийг судалж, санал зөвлөмж боловсруулах” гэрээт ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон байна.

ХЗДХЯ-наас Монголын өмгөөлөгчдийн холбооны их хурлын зардалд 10,237.9 мянган төгрөг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Хөрөнгө гаргах тухай” 179 тоот тогтоолын дагуу Ковид-19 вируст халдварын голомтот бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч, сонсогчдын урамшууллын зардалд 957,180.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

БШУЯ-наас хэрэгжүүлсэн “Оюун-тан” сэдэвт төслийн санхүүжилт 4,000.0 мянган төгрөг олгосон байна.

Төсөвт байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 846,650.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,003,134.3 мянган төгрөг бүрдүүлснээс Сангийн сайдын 2020 оны 225 дугаар тушаалаар 149,559.8 мянган төгрөгийн давсан орлогыг зарцуулах эрх үүсэж, 149,559.8 мянга төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 209 мэдээлэл байршуулахаас хугацаандаа 205 мэдээлэл, хугацаа хоцроож 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,533.5 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна. Үүнд 920,000.0 мянган төгрөгийн гэрээний дүнтэй ажил гүйцэтгэх гэрээнүүдийн холбогдох баримт дутуу, 572,571.7 мянган төгрөгийн үнэ бүхий гал унтраах тусгай зориулалтын автомашиныг тогтоол шийдвэргүй үйл ажиллагаандаа ашиглаж байсан зөрчлүүд гарсныг тайлант онд дахин хянаж үзэхэд дээрх алдаа, дутагдал давтагдаж гараагүй байна. Гэвч ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1753 дугаар тогтоолоор дээрх гал унтраах тусгай зориулалтын автомашины үлдэх өртөг 123,509.7 мянган төгрөг гэж заасан боловч тус сургууль анхны өртгөөр нь нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,357.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,539.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 11,818.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар батлагдсан Төслийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд 8,539.2 мянган төгрөгийн залруулга хийсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1 залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

1. Шилэн дансны тухай хуулийн дагуу цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гарсан тухай бүр мэдээлэх үүргийн дагуу 4 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,-ээр долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй, Үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 11,818.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Монголын менежментийн зөвлөхүүдийн холбоо ТББ-тай хийсэн Чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх гэрээт ажлын үйл ажиллагаа он дамжин хэрэгжиж байгаатай холбоотой дараагийн аудитаар гэрээний гүйцэтгэл, үр дүнг анхаарч үзэх шаардлагатай.

Төсөвт байгууллагын өөрийн орлого болох сургалтын төлбөрийн 1,379,430.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1,003,134.3 мянган төгрөгийн орлого төвлөрснийг сайжруулсан мөнгөн сууриар бүртгэж байгаа боловч дараа жил хүлээн зөвшөөрөх орлогыг урьдчилж орсон орлогоор тайлагнаагүй байгаа нь холбогдох журмын заалттай холбоотой байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлыг тайлант оны төсөвт 8,800,835.3 мянган төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 9,242,372.9 мянган төгрөг буюу 441,537.6 мянган төгрөгөөр төсвийн зарлагын сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргаж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “төсвийн зарчмыг мөрдлөг болгох” 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэж заасантай нийцээгүй, төсвөө бодитой төлөвлөөгүй, Үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн төслийг бодитой төсөвлөхгүй байх, гүйцэтгэл төлөвлөгөөтэй уялдахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн төслийг үндэслэлтэй бодитой төсөвлөж, дээд шатныхаа төсвийн захирагчаар батлуулж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн шууд захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

2. Даатгалын зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын 1 жилийн хугацаатай 15,765.8 мянган төгрөгийн даатгалын гэрээ байгуулсан ба тайлант хугацаанд ногдохгүй 11,818.0 мянган төгрөгийн зардлыг дараа онд хуваарилж бүртгээгүй шууд зардалд бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө.” гэж заасантай нийцэхгүй, Хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Тайлант оны үр дүн алдаатай илэрхийлэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийг аккрузал сууриар хөтлөх, тайлант онд хүлээн зөвшөөрөхгүй зардлыг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн шууд захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/18/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дотоод хэргийн их сургууль		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсвийн төлөвлөлтийг бодитой төсөвлөөгүй.	-	Зөвлөмж өгөх	Захирал СТХ-ийн дарга	П.Батбаатар Л.Лхагважав
2	Тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын 1 жилийн хугацаатай 15,765.8 мянган төгрөгийн даатгалын гэрээ байгуулсан ба тайлант хугацаанд ногдохгүй 11,818.0 мянган төгрөгийн зардлыг дараа онд хуваарилж бүртгээгүй шууд зардалд бүртгэсэн байна.	11,818.0	Зөвлөмж өгөх	Захирал СТХ-ийн дарга	П.Батбаатар Л.Лхагважав
3	Шилэн дансны тухай хуулийн дагуу цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гарсан тухай бүр мэдээлэх үүргийн дагуу нийт 50,714.5 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	-	Албан шаардлага өгөх	Захирал СТХ-ийн дарга	П.Батбаатар Л.Лхагважав
ДҮН		11,818.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 36/АД/70071
САГ- 2021/18/СТА.ТЧЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн дагуу цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гарсан тухай бүр мэдээлэх үүргийн дагуу нийт 4 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дотоод хэргийн их сургуулийн захирал П.Батбаатар, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга Л.Лхагважав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ж.БОЛОРМАА
Д.МӨНХЖИН



This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]

This image shows a full page of a document template designed for handwriting practice or general note-taking. It consists of approximately 28 evenly spaced horizontal dotted lines across the entire width of the page. The background is plain white, and there are no margins, headers, footers, or other markings present.